



Хаврын **хурц нар** нэлээд дээр мандаж
ойр орчмыг **хөхөмдөг манан** бүрхэж
өргөн талд байгаа юмс зэрэглээн дунд **жирвэлзэн**
жирвэлзэн байлаа.

Симфоний эхлэл хэсэг эгшиглэхэд
байгалийн зураг гарна.

Хаврын зураг



Цайдам хөндийн зүүн зах болсон хэсэг дэрс рүү эхээсээ гараад хэдхэн хоносон болов уу гэмээр цайвар цагаан янзагаа дагуулсан шаргачин идээшилсээр орж ирлээ.



Янзага нь тонгочин тоглож орчин тойронд нь өөрөөс нь өөр юмгүй мэт бүхнийг мартан тоглоход



Эх нь тал бүр тийшээ сэрвэлзэн сэртгэнэж өчүүхэн чимээг ч атугай чагнаж нүдэндээ торсон бүхнийг “Энэ юу вэ?, Энэ яах гэж байна?” гэсэн бололтой нарийвчлан ажиглаж явна.

**Уураг нь дуусаагүй өег сүүндээ гэдэс нь
цадсанаас ч юм уу? нялх бие нь тоглоомдоо
ядарснаас ч юм уу?**



**Эсвээс зуун зуун жилээр үргэлжилсэн хатуу
амьдралын сургаалдаа ч юм уу? Бүү мэд. Юу ч л
гэсэн дэрсэнд орсны дараа удалгүй янзага нь
нуугдан унтлаа.**

Зохиолд ямар дүр гарч байна вэ?



Шаргачин



Шаргачин гэж ямар амьтан бол?

Энэ амьтан нь цагаан зээр бөгөөд эрэгчнийг ооно, эмэгчнийг шаргачин, төлийг янзага гэдэг.



Зохиолын эхлэл хэсгийг хөгжим,
зураг, утга зохист үгээр
илэрхийлж байгаа нь
зохиомжийн онцлог гэдгийг
ажиглаж байна уу? Тэгвэл
зохиолын дүрийг хөгжмөөр
илэрхийлж болох уу?
- Бололгүй яах вэ?

- Хөгжимд эдгээр дүрийг хэрхэн дүрсэлснийг сонсьё



?

?

mf

?

A musical staff in treble clef with a key signature of one sharp (F#) and a 2/4 time signature. The notation consists of a sequence of notes and rests: quarter notes, eighth notes, and rests. Three blue arrows point from question marks to the first sharp, the first eighth note, and the 'mf' dynamic marking.

- Хөгжимд эдгээр дүрийг хэрхэн дүрсэлснийг сонсьё

Өөрөөс нь өөр
амьтангүй мэт

Дүр?

Тонгочин тоглож

Хувиргалын тэмдэг

Айзам хэмжээ



mf


Хүчдэл

Дөрөвт, наймт
ноотны зогсоц

Лимбэ



Аялгууны шинж төрх?



Үрээ гэх эхийн хайр

Сэрвэлзэн, сэрэмжлэн, нарийвчлан ажиглах

Дунд зэрэг

Хурд

Moderato


Дээд регистр




Бидний өгүүлсэн энэхүү зохиолд ямар нэр өгч болох вэ?

Шаргачин , Янзага, Янзагатай шаргачин

Цонхоор нь бууны ам шоролзон гарсан машин,
зээрийн хойноос байдаг хурдаараа нэхэхэд




Хурдан хөлдөө **гүн итгэсэн** шаргачин дүүлж
дөрвөн хөл нь газар хүрч байгаа эсэх нь үл
мэдэгдэн хурдална.




Амьд гарч янзагандаа эргэн очоод **язарч чинэрсэн** дэлэнгээ хөхүүлж **учралаар гэрэлтсэн** хайраар янзагынхаа **годгонон тоглож** байгаа **жижигхэн сүүлийг** үнэрлэх **хүслэн их боловч** хөшиж зангирсан хөл нь урагшаа хөдлөхгүй болоод бүх бие нь салганан, амьсгал нь **цээжиндээ багтахгүй оволзон**, саяхан үзэсгэлэн болон сэрвэлзэж байсан хоёр чинх нь **дараа болон дэлдгэнээд**, эцсийн эцэст өөрийн эрхгүй **шургачин ойчлоо**.

Бүх бие нь үхлийн өмнөх чичрэлтээр догдлон байгаа шаргачин эцсийн хүчээ дайчлан янзагаа нуусан зүг рүү амьдралын оч орхин хаяж байгаа нүдээр харахад




- Сонссон хөгжим, уран зохиолд зохиолын дүрүүдийг хэрхэн дүрсэлж байна вэ?
- Та нар оюуны зураглалаар төсөөллөө бүтээгээрэй.



Шаргачин зохиолын энэхүү хэсгийг уран зохиол, хөгжим, уран зурагт дараах байдлаар илэрхийлжээ. Та бүхний зураглалтай тохирч байна уу.







Янзага нь тонгочин тоглож орчин тойронд нь өөрөөс нь өөр юмгүй мэт бүхнийг мартан тоглоход Эх нь тал бүр тийшээ сэрвэлзэн сэртгэнэж өчүүхэн чимээг ч атугай чагнаж нүдэндээ торсон бүхнийг “ Энэ юу вэ?, Энэ яах гэж байна? ” гэсэн бололтой нарийвчлан ажиглаж явна.

